



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/76

Баян-Өндөр сум

Улирлын томуугийн эсрэг
вакцинаар дархлаажуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 8.1, 11.1, 14.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/358 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2023 оны 10 дугаар сарын 10-наас 20-ны өдрүүдэд "Томуугаас сэргийлье" уриан дор зохион байгуулсугай.
2. Улирлын томуугийн эсрэг "GGFLU" вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг хавсралтаар баталсугай.
3. Улирлын томуугийн эсрэг вакцинаар жирэмсэн эмэгтэйчүүд, эрсдэлт бүлгийн хүн ам, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, эцэг, эх асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 2-5 насны хүүхдийг дархлаажуулах мөн заавал хийх товлолын дархлаажуулалтаас хоцорсон 0-15 насны хүүхдийг нөхөн дархлаажуулах ажлыг зохион байгуулахыг Сум, ӨЭМТ-ийн дарга нарт үүрэг болгосугай.
4. Дархлаажуулалтын 10 хоногоор томуугийн болон заавал хийх дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн /С Дулмаа-Юмлаа/, Мэдээлэл, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн /А.Ганчимэг/ нарт даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ХШҮДАХМ /Г.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 10 сарын 16 ны
өдрийн 1/76 р тушаалын хавсралт

УЛИРЛЫН ТОМУУГИЙН ВАКЦИНЫ ХУВААРЬ

8043448 2020030036

№	ЭМБ-ын нэр	2-5 нас	Жирэмсэ н	ЭМБ-ын ажилта н	65-аас дээш болон архаг хууч өвчтэй	Олгох вакци н	Тариу р 1 мл
1	Анхны-Оч ӨЭМТ	1700	80	20	60	1860	1860
2	Мэндцэцэн ӨЭМТ	1600	70	20	50	1740	1740
3	Учралбаяр ӨЭМТ	900	50	10	40	1000	1000
4	Нийцэл ӨЭМТ	610	40	10	30	690	690
5	Үйлсбадрах ӨЭМТ	600	40	10	30	680	680
6	Мөнхийн гэгээ ӨЭМТ	450	40	10	20	520	520
7	Мөнхсүндрэл ӨЭМТ	500	40	10	30	580	580
8	Энхжихмандариваа ӨЭМТ	500	40	10	30	580	580
9	Жаргалант сумын ЭМТ	170	10	10	10	200	200
10	БОЭТ			160		160	160
11	Сургууль, цэцэрлэгийн эмч нар			50		50	50
12	ЭМГ			20		20	20
13	Эрдэнэт сувилалын цогцолбор			30		30	30
14	Эрдэнэт Медикал эмнэлэг			30		30	30
15		7030	410	400	300	8140	8140